



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2016 ОНД САНХҮҮЖҮҮЛСЭН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ



ГЭРЭЭ ДҮГНЭЖ АЖИЛЛААГҮЙ НЬ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ҮР ДҮНГ БУУРУУЛЖ БАЙНА.

Даланзадгад хот
2017 он

**Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн
хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг**

Агуулга

Аудитын гүйцэтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт.....4
Аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Н.Отгонбаяр	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт.....5-6
Аудитын менежер Д.Алдармөнх	Бүлэг 1. Урсгал болон нэг удаагийн арга хэмжээний зардлыг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж баталсан байна.
Ахлах аудитор Т.Хонгорзул	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2013-2016 онд хөгжүүлэх мөрийн хөтөлбөртэй уялдуулан төлөвлөсөн байна.....7
Аудитор Д.Сүрэнжаргал	Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24, 6 дугаар зүйлийн 6.6.6 дахь заалтуудын шаардлагыг хангаагүй 1,667.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.....7
Шинжээч Ш.Отгонбаяр	- Барилга барих газрын зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.....7 - ТЭЗҮ, зураг, төсөвгүй төсөл арга хэмжээг төлөвлөж байна.....8 - Батлагдсан төсөл арга хэмжээний өртөг үндэслэлгүйгээр нэмэгдэж санхүүжих дүнд өөрчлөлт орж тусгагдсан хөрөнгө оруулалт байхгүй байна.....9 - Төсөл арга хэмжээний нэр, эхлэх дуусах хугацаа, байршил болон ангилал зөрүүтэй тусгагдсан хөрөнгө оруулалт байхгүй байна.....9
	Бүлэг 2. Худалдан авах ажиллагааны ил тод, шуурхай байдлыг сайжруулах шаардлагатай байна.
	- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлэхгүй байна.....10 - Худалдан авах ажиллагааны журмыг зөрчиж, өрсөлдөөнийг хязгаарласан тендер шалгаруулалт байхгүй байна.....10 - Хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа ч үр дүнг тайлагнахгүй байна.....10 - Худалдан авах ажиллагаанаас бий болсон төсвийн хэмнэлтийг хуулийн дагуу зарцуулжээ.....11 - Эрх шилжсэн ажлууд хугацаандаа хийгдэж дууссан

**Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн
хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг**

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70533539 дугаарын утсаар харилцана уу. ХАЯГ: Нутгийн удирдлагын ордон 303 тоот Даланзадгад сум Өмнөговь аймаг	байна.....11 • Батлагдсан зориулалтын дагуу төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан байна.....11 Бүлэг 3. Захиалагч гэрээ дүгнэж, хэрэгжилтийг хангуулаагүй нь хөрөнгө оруулалтыг үр өгөөжийг бууруулж байна. • Гэрээний хугацаа хэтрүүлэн ашиглалтад хүлээлгэн өгөх зөрчил арилаагүй байна.....12 • Санхүүжилтийг зориулалтын дагуу олгожээ.....12 • Батлагдсан зураг төсөвт өөрчлөлт орсон төсөл арга хэмжээ байхгүй байна.....13 • Санхүүжих дүнг дутуу батласанаас хугацаа хойшлогдсон төсөл арга хэмжээ байхгүй байна...14 • Өмнөх онд өгсөн гэрээ дүгнэж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.....14 • Соёл амралтын цогцолбор улсын комисс хүлээн аваагүй байхад үйл ажиллагаа явуулсан байна...14 • Зарим хөрөнгө оруулалт чанарын болон ашиглалтын шаардлага хангахгүй байна.....14-16 Дүгнэлт.....17-18 Албан шаардлага.....19 Холбогдох байгууллагын санал Тайлан баталгаажуулсан Тэргүүлэх аудиторын тушаал Хавсралтууд Судалгаа №1. 2016 онд шинээр эхэлсэн буюу зураг төсөвт өөрчлөлт орсон төсөл, арга хэмжээний судалгаа /<i>орон нутаг</i>/ Судалгаа №2. Худалдан авах ажиллагаа, тендер шалгаруулалт нь 2016 онд зохион байгуулагдсан төсөл, арга хэмжээний судалгаа /<i>улс болон орон нутаг</i>/ Судалгаа №3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилт, санхүүжилтийн судалгаа /<i>улс болон орон нутаг</i>/
---	--



Товчилсон үгийн жагсаалт

ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
УИХ	Улсын их хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
НБХ	Нийгмийн бодлогын хэлтэс
ХБТХ	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үнэлгээ

АУДИТЫН НЭР:

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

АУДИТЫН КОД:

ҮАГ-ГАГ/2017/02-ГА-ӨМАГ

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Аудитыг Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны А/12 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Орон нутгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ

Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрхи зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх

ХАМРАХ ХҮРЭЭ

Аудитаар орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг Аймгийн ЗДТГ, ХБТХ, СТСХ, НБХ, ХААА, орон нутгийн өмчийн газар, ГХБХБГазар, сумдын ЗДТГазар болон бусад холбогдох байгууллагууд хамрагдлаа.

АУДИТЫН АРГА ЗҮЙ

Аудитыг гүйцэтгэхэд ТХШС, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100)-ийг ашиглах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийж нэгтгэн аудитын дүнг боловсруулж, түүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

АУДИТАД АШИГЛАСАН ШАЛГУУР:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт
- Төсвийн тухай хууль

**Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн
хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг**

- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Иргэний хууль
- Дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд
- Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”
- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Засгийн газрын 2015 оны 377 дугаар тогтоол
- Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолууд
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

Бүлэг А

Урсгал болон нэг удаагийн арга
хэмжээний зардлыг хөрөнгө
оруулалтын төлөвлөгөөнд
тусгажээ.

1.1 Аймгийн эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2013-2016 онд хөгжүүлэх мөрийн хөтөлбөртэй уялдуулан Аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 9/7 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх 24,272.3 сая төгрөгийн 58 төсөл арга хэмжээг баталсан байна.

2016 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн 2/1 дугаар тогтоолоор төсвийн тодотгол хийж 68 төсөл арга хэмжээнд 22,759.9 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталжээ. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 15,739.1 сая төгрөгийн 47 төсөл, арга хэмжээ
2. Байгаль хамгаалах чиглэлээр 7,020.8 сая төгрөгийн 21 төсөл, арга хэмжээ

*Хүснэгт 1. Батлагдсан төсөл, арга хэмжээний зориулалт
(сая.төгрөг)*

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөл арга хэмжээний тоо	Мөнгөн дүн
1	Барилга байгууламж	22	18,868.7
2	Тоног төхөөрөмж	19	1,349.9
3	Их засвар	8	874.6
4	Бусад төсөл хөтөлбөр	19	1,666.7
	Нийт	68	22,759.9

Барилга байгууламж, авто зам тавихад 82.9 хувь, их засвар 3.8 хувь, тоног төхөөрөмж 5.9 хувь, төсөл хөтөлбөр 7.3 хувийг тус тус эзэлж байна.
/Судалгаа №1/

1.2 Батлагдсан хөрөнгө оруулалтын 1,666.7 сая төгрөг буюу 7.3 хувь нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24¹, 6 дугаар зүйлийн 6.6.6² дахь заалтуудыг зөрчиж орон нутгийн өмчлөлд хамаарахгүй, урсгал зардал болон нэг удаагийн арга хэмжээнүүдийг хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгасан байна. Тухайлбал:

- Төрийн албан хаагчдийн орон сууц эмчилгээний зардалд 500.0 сая төгрөг
- Оюутны тэтгэлэгт хөтөлбөрт 195.0 сая төгрөг

¹ Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг

² Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх

**Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн
хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг**

- “Монгол тэмээ-999” дэлхийн дээд амжилтанд бүртгүүлэх тэмээний уралдаан зохион байгуулах 179.7 сая төгрөг
- Орон нутгийн соёлын өвийг сэргээн Цамын бүжиг туурвихад 80.0 сая төгрөг
- Хүнс хөдөө аж ахуйн газрын материаллаг баазыг бэхжүүлэхэд 39.0 сая төгрөг
- Хилийн цэргийн 131 дүгээр ангийн цэргийн байр барихад 30.0 сая төгрөг
- Хууль сахиулах байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах зорилтын хүрээнд 50.0 сая төгрөг
- Өрх гэр бүлийг дэмжих, ажилтай орлоготой эмэгтэйчүүд, 40-с дээш насны ажил олгоход бэрхшээлтэй иргэнийг ажлыг байраар хангах хөтөлбөрт 300.0 сая төгрөг
- Аймгийн нутаг дэвсгэрийн хөрсний доройтол, цөлжилтийн зэрэглэл, байгалийн ургамлын нөөцийг тогтоож, ногоон ном гарган менежментийн төлөвлөгөө боловсруулах 100.0 сая төгрөг
- Мод тарьж ургуулсан иргэдэд урамшуулал 30.0 сая төгрөг

Иймд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын жагсаалтыг батлуулахдаа Төсвийн тухай хуулиар тодорхойлсон тухайн шатны төсөвт хамаарах хөрөнгө оруулалт мөн эсэх, тухайн шатны төсөвт хамаарагдаж байгаа хэдий ч “*хөрөнгө оруулалт*” гэсэн томъёололд нийцэж байгаа эсэхийг судлаж байх шаардлагатай байна. Цаашид Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах тухай албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

1.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд хийгдэхээр тусгагдсан Гурвантэс, Булган, Номгон сумдын ЗДТГ-ын конторын барилга угсралтын ажлын газрын зөвшөөрөлийг Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4³ -д заасан дагуу тухайн сумдын Засаг даргын захирамжаар 2014, 2015 онуудад олгогдсон байна.

1.4 Тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр тусгасан 3 барилга, 15 их засварын ажлуудыг зураг, төсвийг хөрөнгө оруулалт батлагдсан дараа буюу 2016 онд гүйцэтгүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дахь заалтыг зөрчсөн байна. Тухайлбал:

- Гурвантэс, Булган, Номгон сумдын ЗДТГ-ын конторын барилга нийт 1,849.6 сая төгрөгийн өртөгтэй
- Даланзадгад сумын морь барианы газрын өргөтгөл, шинэчлэлийн ажил 78.9 сая төгрөгийн өртөгтэй
- Төв цэнгэлдэх хүрээлэнгийн засвар 469.5 сая төгрөгийн өртөгтэй

³ Хөрөнгө оруулалтын төсөвт техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг тусгана

**Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн
хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг**

- Буянт хотхон хүүхдийн зуслангийн 4 айлын орон сууцны барилгын засвар 38.7 сая төгрөгийн өртөгтэй
- Цагдаагийн газрын төв байрны урсгал засвар 80.0 сая төгрөгийн өртөгтэй
- Далангийн цөөрөм лайдах 41.6 сая төгрөгийн өртөгтэй
- 15 сумдын булгийн эхийг хашиж хамгаалах ажил 60.0 сая төгрөгийн өртөгтэй ажлууд байна.

Цаашид хөрөнгө оруулалтын жагсаалтыг батлуулахдаа техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг тусгаж байх тухай албан шаардлагыг аймгийн Засаг даргад албан шаардлага хүргүүллээ.

1.5. Батлагдсан төсөл арга хэмжээний өртөг үндэслэлгүйгээр нэмэгдэж санхүүжих дүнд өөрчлөлт орж тусгагдсан хөрөнгө оруулалт байхгүй байна.

1.6. Төсөл арга хэмжээний нэр, эхлэх дуусах хугацаа, байршил болон ангилал зөрүүтэй тусгагдсан хөрөнгө оруулалт байхгүй байна.

1.7. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд 3,918.7 сая төгрөгийн өртөгтэй 13 ажлын үлдэгдэл санхүүжилтийг он дамжин санхүүжүүлэхээр тооцож, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгаж батлуулсан байна. Үүнд:

- Хүрмэн, Ханхонгор, Булган, Манлай, Баяндалай, Мандал-Овоо сумдын уурын зуухны тогоо шинэчлэх ажил 365.7 сая төгрөг,
- Баяндалай, Хүрмэн, Ноён сумдын ЗДТГ-ын барилга усгалтын ажил 1,390.8 сая төгрөг
- Ханбогд сумын эмнэлгийн засварын ажил 1390.8 сая төгрөг,
- Виз бүртгэлийн тоног төхөөрөмж худалдан авах ажил 30.2 сая төгрөг,
- Даланзадгад сумын гэр хорооллын зарим хэсгийг цэвэр, бохир усны шугамд холбох ажил 2,113.4 сая төгрөг,
- Даланзадгад сумын хог хаягдлын цэгийн барилгын ажил 18.6 сая төгрөгийн өртөгтэй ажлууд байна.

Бүлэг Б

Худалдан авах ажиллагааны ил
тод, шуурхай байдлыг сайжруулах
шаардлагатай байна.

2.1 Аймгийн Худалдан авах ажиллагааны алба 2016 онд бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг Аймгийн Засаг даргаар батлуулан, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 48 дугаар зүйлийн 48.5⁴ -д заасан дагуу <http://www.omnogovi.gov.mn/>, www.e-procurement.mn сайтад нийтэлсэн байна.

Батлагдсан төлөвлөгөөнд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 18,148.6 сая төгрөгийн 25 төсөл арга хэмжээ, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 9,896.3 сая төгрөгийн 25 төсөл арга хэмжээ, бусад төсөл хөтөлбөрийн хүрээнд 9,268.8 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулагдахаар тусгагджээ. Захиалагч төсвийн тодотгол хийж тухайн жилийн явцад шинээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах санхүүжилтийн дүнд өөрчлөлт орсон байхад худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “ТБОНӨХБАҮХАА-г төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.7⁵ дахь заалтыг зөрчсөн байна.

2.2 Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Боловсрол соёл шинжлэх ухааны яамнаас 235.0 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын багцаас 50.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 8,466.0 сая төгрөгийн 39 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна. ТБОНӨХБАҮХАА-д мөрдөх журмын дагуу босго үнийн нөхцлийг хангасан 20 төсөл арга хэмжээнд нээлттэй тендер, 2 төсөл арга хэмжээнд шууд гэрээ, 21 төсөл арга хэмжээнд харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт зохион байгуулжээ./судалгаа №2/

2.3 Тендер шалгаруулалтад үнэлгээний хороо гишүүдийн ирцийн бүрдлээс хамааран нээлттэй тендер шалгаруулалтыг 30 хоног, харьцуулалтын тендер шалгаруулалтыг урилга илгээсэн өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй хоногоор тогтоон, үнэлгээ хийж дүгнэлтийг захиалагчид хүргүүлэн ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2⁶ -д заасан дагуу тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулсан байна. Захиалагч гэрээ байгуулсан өдөрт

⁴ Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр нийтэд зарлан мэдээлнэ.

⁵ Захиалагч төсвийн тодотгол хийхэд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Энэ тодотголд тухайн жилийн явцад шинээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, түүнийг санхүүжүүлэх буюу шинээр төсөл, арга хэмжээ эхлүүлэх шийдвэрийн хүрээнд хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааг тусгаана. Тодотгосон төлөвлөгөөг журмын 2.6, 2.9-д заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

⁶ Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 5-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна.

**Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн
хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг**

багтаан тендер шалгаруулалтын үр дүнг цахим системд нийтлээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2013 оны 84 дугаар тушаалаар батлагдсан “Цахим хуудаст худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам”-ын 7.1⁷, 7.2⁸ дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Цаашид дээрхи журмыг хэрэгжүүлж ажиллах тухай албан шаардлагыг Орон нутгийн өмчийн газрын даргад хүргүүллээ.

2.4 Тайлант онд зохион байгуулагдсан 39 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтаас 468.1 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна. Худалдан авах ажиллагаанаас бий болсон төсвийн хэмнэлтийг зарцуулахдаа Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5⁹ дахь заалтыг баримталж ажилласан байна.

2.5 ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6¹⁰-д заасан дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 35.0 сая төгрөгийн өртөгтэй Ноён сумын сургуулийн барилгын сантехник засварын ажил, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 21.0 сая төгрөгийн өртөгтэй Манлай сумын төвийн хүн амын усан хангамжийг сайжруулах инженерийн хийцтэй худаг гаргах ажил, 60.0 сая төгрөгийн өртөгтэй 15 сумдын булаг шандны эх хаших ажил, 16.0 сая төгрөгийн өртөгтэй Цогт-овоо сумын нутгийн удирдлагын ордны дээврийн засварын ажлууд тухайн сумдын Засаг даргын тамгын газарт эрх шилжсэн байна. Эрх шилжсэн ажлууд ТБОНӨХБАҮХАТХ-ын дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулжээ. Тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлсэн байна.

2.6 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд хийгдэхээр тусгагдсан хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд батлагдсан зориулалтын дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан байна.

⁷ Захиалагч гэрээ байгуулсан өдөрт багтаан тендер шалгаруулалтын үр дүнг цахим системд нийтлэнэ

⁸ Тендер шалгаруулалтын үр дүнгийн талаар дор дурдсан мэдээллийг системд мэдээлнэ.....

⁹ Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын дараах арга хэмжээнд зарцуулахыг хориглоно.....

¹⁰ Аймаг нийслэлийн засаг даргын тамгын газар нь шаардлагатай гэж үзвэл сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт энэ хуулийн 45.2.2-т заасан эрхээ шилжүүлж болно.

Бүлэг В

Захиалагч гэрээний хэрэгжилтийг
хангуулж ажиллаагүй нь хөрөнгө
оруулалтын үр өгөөжийг бууруулж
байна.

3.1 Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтаар шаардлагад нийцсэн гүйцэтгэгчтэй ТБОНӨХБАҮХАТХ-ийн 40 дугаар зүйлийн 40.2¹¹, 40.3¹²-д заасан дагуу захиалагч тал 7,977.8 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулсан байна. /судалгаа3/

Гэрээ байгуулан гүйцэтгэж байгаа ажлын 64.8 хувь нь хугацаандаа, 35.2 хувь нь 1-166 хоногоор хугацаа хэтрүүлэн ашиглалтад орсон байна. Тухайлбал:

- 1200 хүүхдийн сургуулийн барилгын ажил 22 хоног
- Буянт хүүхдийн зуслангийн тохижилтын ажил 3 хоног
- Баяндалай сумын уурын зуухны ажил 84 хоног
- Хүрмэн сумын уурын зуухны ажил 166 хоног
- Номгон сумын нутгийн удирлагын ордон 65 хоног
- Даланзадгад суманд 1 гүн өрмийн худаг гаргах, 15 км урттай услалтын систем суурилуулах ажил 72 хоног
- Мандал-Овоо сумын уурын зуух нийлүүлэх ажил 92 хоног
- Булган сумын уурын зуух нийлүүлэх ажил 24 хоног
- Даланзадгад сумын 5-р баг, Ханхонгор сумын Жаргалант багийн төвийн барилгын засварын ажил 86 хоног
- Хилийн цэргийн 131-р ангид камер нийлүүлэх ажил 20 хоног
- Цагдаагийн газрын төв байрны урсгал засвар 7 хоног
- Даланзадгад сумын 1,2,4,5,6,7 дугаар багийн гэр хорооллын зарим хэсэгт цэвэр, бохир усны шугам сүлжээний ажил 61 хоног
- Далан булгийн хөв цөөрмийг лайдах, засварлах ажил 43 хоног

Гэрээний хугацаа хэтрүүлж ашиглалтад хүлээлгэн өгч байгаа нь хөрөнгө оруулалт чанаргүйдэх, хэрэгцээ шаардлагыг бууруулах, үр ашиггүй хөрөнгө бэлтгэх эрсдлийг дагуулж байна. Иймд Иргэний тухай хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.1¹³ дахь заалтыг зөрчиж гэрээнд заасан хугацаа хэтрүүлж байгаа дээрхи зөрчлийг арилгаж, цаашид гэрээний хэрэгжилтийг дүгнэж ажиллах тухай албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын даргад хүргүүллээ.

3.2 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд хийгдэх хөрөнгө оруулалтыг 22,759.9 сая төгрөгөөр батлаж, гүйцэтгэлээр 21,467.7 сая төгрөг зарцуулжээ.

¹¹ Хамгийн сайн үнэлэгдсэн тендер болон тендерийн баримт бичигт захиалагчийн тодорхойлсон худалдааны болон техникийн шаардлага нь худалдан авах гэрээний үндсэн нөхцөл болно


¹² Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна дараахь нөхцөл заавал тусгана.....

¹³ Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх

**Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн
хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг**

Үүнээс Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24¹⁴, 6 дугаар зүйлийн 6.6.6¹⁵ дахь заалтуудын шаардлагад нийцсэн хөрөнгө оруулалтад 20,129.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. /судалгаа №4/

Сангийн сайдын 2012 оны 290 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.19¹⁶ -д заасан дагуу ТЭЗҮ болон зураг төсвийн зардалд 234.8 сая төгрөг, захиалагч хяналтын зардалд 724.0 сая төгрөг, гүйцэтгэгчид 18,499.8 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгосон байна. Графикаар харуулбал:



Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд хийгдсэн хөрөнгө оруулалтыг өмнөх онтой харьцуулахад боловсрол, соёлын салбар 1,841.2 сая төгрөг, төрийн захиргааны салбар 3,330.0 сая төгрөг, зам тээвэр барилга хот байгуулалтын салбар 7,467.2 сая төгрөг, хүнс хөдөө аж ахуйн салбар 98.8 сая төгрөгөөр буурсан бол эрүүл мэнд, спортын салбар 493.2 сая төгрөг, байгаль орчин аялал жуулчлалын салбар 4,164.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.3 Төсөл арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн талаас ажлын үе шатны явцад хяналт тавьж, ажлын гүйцэтгэлийг Сангийн сайдын 2012 оны 290 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3 дугаар зүйлд заасан баримт материалыг үндэслэн санхүүжилт олгожээ. Ажлын явцад зураг төсөвт өөрчлөлт орсон төсөл арга хэмжээ байхгүй байна.

¹⁴ Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг

¹⁵ Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх

¹⁶ Захиалагч барилгын ажлын зардал, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн үнэ, техник хяналтын зардал, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох баримт, материалыг үндэслэн шилжүүлнэ.

3.4 Төсөл арга хэмжээний санхүүжих дүн дутуу батлагдсан, бодит гүйцэтгэлийг үндэслэн санхүүжүүлээгүйгээс хэрэгжих хугацаа хойшилсон төсөл, арга хэмжээ байхгүй байна.

3.5 Тайлант онд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн 43 төсөл арга хэмжээнд захиалагч тал явцын хяналтыг хэрэгжүүлэн 40 төсөл арга хэмжээг ашиглалтад хүлээн авсан байна. Төсөв санхүүгийн байдлаас шалтгаалан 7,632.6 сая төгрөгийг өртөгтэй Даланзадгад-Баяндалай-Гурвантэс чиглэлийн 25 км хатуу хучилттай автозамыг барих ажил, 908.6 сая төгрөгийн өртөгтэй Булган сумын нутгийн удирдлагын ордон барих барилга угсралтын ажил, 9.9 сая төгрөгийн өртөгтэй аймгийн төв доторх хатуу хучилттай авто замын 37 цэгт засвар хийх ажлууд 2017 онд ашиглалтад хүлээлгэн өгөхөөр гэрээг сунгажээ.

Тайлант онд гэрээ байгуулан гүйцэтгэж байгаа ажлын 64.8 хувь нь хугацаандаа, 35.2 хувь нь 1-166 хоногоор хугацаа хэтрүүлэн ашиглалтад орсон нь өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс шалтгаалжээ.

3.6 Гэрээнд заасан хугацаандаа хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээг Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1¹⁷, 48.5¹⁸-д заасан дагуу улсын комиссын бүрэлдэхүүн хүлээн авч, хурлын тэмдэглэл үйлдэн баталгаажуулсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2014 оноос хойш он дамжин хийгдэж байгаа Соёл амралтын цогцолборыг улсын комисс хүлээн аваагүй байхад 2016 оны 2, 3 дугаар улиралд үйл ажиллагаа явуулсан нь Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3¹⁹ дахь заалтыг зөрчсөн байна.

Цаашид барилга угсралтын ажлыг улсын комисс хүлээж авсан дараа үйл ажиллагаа эхлүүлэх, гарсан зөрчлийг дахин давтахгүй байх тухай албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын даргад албан шаардлага хүргүүлжээ.

3.7 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн зарим хөрөнгө оруулалт ашиглалтын явцад чанарын шаардлага хангахгүй, гүйцэтгэгч компани улсын комиссоос өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлээгүй, эзэмшигч байгууллага хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, ашиглалт хамгаалалт байхгүй зэрэг нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

Чанаргүй хийгдсэн ажлууд:

- Даланзадгад сумын морь барианы газрын өргөтгөл, шинэчлэлийн 78.9 сая төгрөгийн өртөгтэй ажлын зарим дээврийн хэсэг нимгэн төмрөөр хийгдсэнээс салхинд хуурсан /Зураг-1/
- Мандал-Овоо, Баяндалай сумдад 120.2 сая төгрөгийн өртөгөөр “Хайрхан бар” ХХК нийлүүлсэн уурын зуухны тогоо ашиглах явцад зуухны ам

¹⁷ Барилгын ажлын зөвшөөрөлд заасан дагуу нөхцөл, зураг төслийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулан энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулна

¹⁸ Захиалагч энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагад барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт гаргах бөгөөд дараах бичиг баримт хавсаргана.

¹⁹ Гэрчилгээ олгогдоогүй, дуусаагүй барилга байгууламжид үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

**Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн
хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг**

хайлж цоорсон, дотор өрлөг нурж аваарын клапан буудсан, утаа сорогч ажиллахаа байсан зэргээс шалтгаалан цаашид ашиглах боломжгүй /Зураг-2/

- Ноён суманд 949.5 сая төгрөгийн өртөгөөр баригдсан НУО-ын барилга ашиглалтын явцад хананд цууралт өгсөн, дээврээс ус гоожсон, хаалганы цоожнууд эвдэрсэн /зураг-3, зураг-4/
- Ахмадын хээрийн сувилалд 19.0 сая төгрөгийн өртөгөөр гаргасан гүний худаг усны ундрага багатайгаас ашиглах боломжгүй /Зураг-5/

Улсын комиссоос өгсөн үүргийг хэрэгжүүлээгүй:

- Даланзадгад суманд баригдсан 92.8 сая төгрөгийн өртөгтэй хог хаягдлын цэгийн барилгын ажлыг 2016 оны 06 дугаар сарын 24-нд улсын комисс хүлээн авч гүйцэтгэгчээр дутуу хийгдсэн ажлуудыг дуусгах үүрэг өгсөн ч “Кайши” ХХК 2017 оны 03 дугаар сарын байдлаар ямар ч ажил хийгээгүй, ашиглах боломжгүй /Зураг-6/

Хөрөнгийн бүртгэлд тусгаагүй:

- Хилийн цэргийн 0131-р ангид нийлүүлэгдсэн 5.1 сая төгрөгийн өртөгтэй DJI Phanton 4 камер /Зураг-7/
- Орон нутгийн соёлын өвийг сэргээн Цамын бүжгийг туурвих 80.0 сая төгрөг

Хөрөнгийн ашиглалт хамгаалалт байхгүй:

- Далан булгийн орчны тохижилтын ажил 54.3 сая төгрөг /зураг-8/

Иймд дээрх чанаргүй хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7²⁰-д заасан дагуу гүйцэтгэгч эзэмшигчийн аль буруутай этгээдээр зөрчлийг арилгуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2²¹ дахь заалтын дагуу бүртгэлгүй байгаа хөрөнгийг бүртгэлд тусгуулах, ашиглалт хамгаалалтыг сайжруулах тухай албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын даргад хүргүүллээ.



Зураг-1. Морь барианы газар



Зураг-2. Баяндалай сумын уурын зуух

²⁰ энэ хуулийн 14.6-д заасан хугацаанд гарсан зөрчлийг захиалагч, зураг төсөв зохиогч, гүйцэтгэгч, материал ханган нийлүүлэгч, эзэмшигчийн аль буруутай этгээд арилгаж, хохирлыг барагдуулна

²¹ 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалтыг

**Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн
хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг**



*Зураг-3. Ноён сумын НУО-ны
барилга*



*Зураг-4. Ноён сумын НУО-ны
барилга*



*Зураг-5. Ахмадын хээрийн
сувилалын гүн өрмийн худаг*



Зураг-6. Хогийн цэгийн барилга



Зураг-7. DJI Phantom 4 камер



Зураг-8. Далан булаг

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна. Үүнд:

- Аймгийн эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2013-2016 онд хөгжүүлэх мөрийн хөтөлбөртэй уялдуулан төлөвлөсөн байна.
- Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24, 6 дугаар зүйлийн 6.6.6 дахь заалтуудын шаардлагад нийцээгүй 1,667.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.
- ТЭЗҮ, зураг, төсөвгүй төсөл арга хэмжээг төлөвлөж байна.
- Батлагдсан төсөл арга хэмжээний өртөг үндэслэлгүйгээр нэмэгдэж санхүүжих дүнд өөрчлөлт орж тусгагдсан хөрөнгө оруулалт байхгүй байна.
- Төсөл арга хэмжээний нэр, эхлэх дуусах хугацаа, байршил болон ангилал зөрүүтэй тусгагдсан хөрөнгө оруулалт байхгүй байна.
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлэхгүй байна.
- Худалдан авах ажиллагааны журмыг зөрчиж, өрсөлдөөнийг хязгаарласан тендер шалгаруулалт байхгүй байна.
- Хуульд заасан хугацаанд худалдан авах авах ажиллагааг зохион байгуулж байгаа хэдий ч үр дүнг олон нийтэд ил тод тайлагнахгүй байна.
- Худалдан авах ажиллагаанаас бий болсон төсвийн хэмнэлтийг хуулийн дагуу зарцуулжээ.
- Эрх шилжүүлсэн ажлууд хугацаандаа хийгдэж дууссан байна.
- Батлагдсан зориулалтын дагуу төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.
- Гэрээний хугацаа хэтрүүлэн ашиглалтад хүлээлгэн өгөх зөрчил арилаагүй байна.
- Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг зориулалтын дагуу олгожээ.
- Батлагдсан зураг төсөвт өөрчлөлт орсон төсөл арга хэмжээ байхгүй байна.
- Санхүүжих дүнг дутуу батласанаас хугацаа хойшлогдсон төсөл арга хэмжээ байхгүй байна.
- Өмнөх онд өгсөн гэрээ дүгнэж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Соёл амралтын цогцолборыг улсын комисс хүлээн аваагүй байхад үйл ажиллагаа явуулсан байна.
- Зарим хөрөнгө оруулалт чанарын болон ашиглалтын шаардлага хангахгүй байна.

**Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн
хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг**

АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Н.ОТГОНБАЯР

АЛБАН ШААРДЛАГА

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд шаардаж байна. Үүнд:

Аймгийн засаг дарга Н.Наранбаатар танаа:

- Хөрөнгө оруулалтын бус урсгал болон нэг удаагийн арга хэмжээний зардлыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан зөрчлийг таслан зогсоох
- Зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж байх

Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Ө.Баянмөнх танаа:

- Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээг гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын гэрээ дүгнэж, хэрэгжилтийг хангуулж ажиллах
- Чанаргүй хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг холбогдох хуулийн дагуу гүйцэтгэгч эзэмшигчийн аль буруутай этгээдээр зөрчлийг арилгуулах, хөрөнгийг бүртгэлд тусгуулах, ашиглалт хамгаалалтыг сайжруулах
- Улсын комисс хүлээж аваагүй байхад үйл ажиллагаа явуулсан зөрчлийг таслан зогсоож дахин гаргахгүй байх

Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Бурмаа танаа:

- Худалдан авах ажиллагааны ил тод, шуурхай байдлыг хангаж, холбогдох журмыг мөрдөж ажиллах